

### Тарваган тахал

Тарваган тахал нь мэрэгч амьтдаас хvнд халддаг гоц аюулт халдварт овчин юм. Тарваган тахлаар тарвага, зурам, vхэр огодой, vлийн болон гэрийн цагаан оготно, чичvвл зэрэг мэрэгчдээс гадна хvн овчилдог. Овчин vвсгэгчийг мэрэгчдийн дунд бvврэг дамжуулдаг. Овчин vвсгэгч нь мэрэгчдийн арьсанд 23 хоног, хоол хvнсэнд 2-4 сар, овчтний цэр, идээ, цусанд 4-165 хоног овчин vвсгэх чадвартайгаар хадгалагдана.

### Халдвар хэрхэн дамжих вэ?

Халдварлагдсан бvврэгт хазуулах, овчилсон амьтныг овчих, арьс, маханд хvрэлцэхэд арьс салстаар, тарваганы махыг тvвхий, шvврхий идсэн тохиолдолд хоол боловсруулах замаар, нvх, ичээ ухах вед болон уушгины хэлбэрийн тахлаар, овчилсон хvнээс амьсгалын замаар халдвар дамжина.

### Илрэх шинж тэмдэг

Гэнэт ондор халуурах, толгой хvчтэй овдох, эргэх, дотор муухайрах, боолжих, тайван бус болж, нойргvйтэх, арьс салстаар халдвар авсан вед булчирхай томорч хvчтэй эмзэглэх, амьсгалын замаар халдвар авсан тохиолдолд гэнэт ондор халуурч цээжээр овдох, ханиалгах, цустай цэр гарах, амьсгаадах, хоол боловсруулах замаар халдвар авсан вед суулгах, заримдаа цусаар суулгах шинжvвд илэрнэ.

### Сэргийлэлт

1. Сэжиг бvхий vхсэн мэрэгч амьтдын сэг зэмтэй тааралдвал мэргэжлийн байгууллагад хандах

2. Нохой зууж ирсэн тарвагад хүрэхгүй байх, ходолгоон нь удааширсан тарвагыг агнахгүй байх, арьс, махыг ашиглахгүй байх
3. Тарвагыг нохойгоор бариулах, хавхаар агнахыг цээрлэх
4. Овчний шинж тэмдэг илэрсэн тохиолдолд эмнэлгийн байгууллагад мэдэгдэх гэхдээ овчтонтой ойр байсан хүнээр хэл хүргүүлэхээс татгалзах, учир нь халдвар тархаж болзошгүй юм.
5. Сэжигтэй овчтон болон эд материалтай холилдсон хүнийг тусгаарлах
6. Сэжиг бүхий эд материал, овчтоний хэрэглэж байсан зүйлсд онош тодрохоос нааш хүрэлцэхгүй байх
7. Тарвага агналтыг зовшоорсон газарт, тогтоосон хугацаанд сэргийлэх тарилга хийлгэсэн хүн хийх
8. Ан хийж байх үедээ халад, бээлий хэрэглэж занших
9. Гэртээ тарвага овчих, нойтон арьс хадгалах, боловсруулаагүй мах оруулахыг цээрлэх
10. Голомттой нутгийн анчид, арьсны наймаачид, тарваганы мах идэх дуртай хүмүүсийг сэргийлэх вакцинд хамруулах шаардлагатай юм.